



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 0/122

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.4, 23 дугаар зүйлийн 23.1.6, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2-т тус тус заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү аргачлалын дагуу төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийлгэх ажлыг жил бүр тогтоосон хугацаанд зохион байгуулахыг Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Бат-Отгонд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Б.Доньжчимбууд даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н.ГАНБОЛД

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС АВЛИГЫН ЭСРЭГ ЯВУУЛЖ БУЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Нэг. Оршил

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран 2008 оноос яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн. Үзүүлбэл:

Он	Төлөвлөгөө хэрэгжүүлсэн байгууллага						Нийт
	УИХ-аас байгуулагддаг байгууллага	Яам	Агент-лаг	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Дүүрэг	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд	
2008 он	-	11	15	-	-	-	26
2009 он	-	11	42	1	-	-	54
2010 он	-	11	42	22	-	-	75
2011 он	-	11	42	22	-	-	75
2012 он	-	16	28	22	-	10	76
2013 он	7	16	27	22	-	48	120
2014 он	7	16/13	28	22	9	50	132

Төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, хүрсэн үр дүн зэргээс шалтгаалан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар **авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг** зөвхөн төлөвлөсөн хүрээнд биш байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулж ажиллахыг зорьж байна.

Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор энэхүү аргачлалыг боловсруулав.

Аргачлалыг БНСУ-ын Авлигатай тэмцэх ба хүний эрхийн хорооны 2002 оноос хэрэгжүүлсэн Авилгын эсрэг санал, санаачлагын үнэлгээ, 2012 оноос хэрэгжүүлсэн Авилгын эсрэг өрсөлдөх чадварын үнэлгээний арга зүйд тулгуурлан Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан юм.

Хоёр. Зорилго

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх, хэрэгжилтийг хангуулах;
- Албан хаагчдын шударга байдлын түвшинг нэмэгдүүлэх;
- Авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санал санаачилга, хүчин чармайлтыг дэмжих;
- Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй үлгэр жишээ, тэргүүн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх;
- Төрийн байгууллага хоорондын өрсөлдөөнийг бий болгох;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгөх, энэхүү үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах.

Гурав. Ач холбогдол

- Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлнэ;
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана;
- Байгууллага хоорондын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ;
- Төрийн байгууллагын үйл ажиллагаанд тавих иргэний хяналт сайжирна;
- Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр дүнд ахиц дэвшил гарна.

Дөрөв. Эрх зүйн үндэслэл

Авлигын эсрэг хууль:

- 18 дугаар зүйл. 18.1.1. улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 18 дугаар зүйл. 18.1 4. Төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах;
- 18 дугаар зүйл. 18.4.4. авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилтай холбогдуулан төрийн байгууллагаас холбогдох мэдээ, судалгаа, тайлан гаргуулан авах;
- 18.4.14. хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хяналт тавих, мэдээлэл өгөх журмын биелэлтийг шалгах.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль:

- 28 дугаар зүйл. 28.1. Энэ хуулийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрхэн дагаж мөрдөж байгаад дараахь байгууллага хяналт тавина:
28.1.2. энэ хуулийн 28.1.1-д зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар.

Тав. Баримтлах зарчим

5.1. Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэх явцад дараахь зарчмыг баримтална:

- Шударга байх;

- Тэгш байдлыг хангасан байх;
- Санаачилгатай байх;
- Ил тод, нээлттэй байх;
- Хөндлөнгийн хараат бус байх;
- Олон нийтийн оролцоонд тулгуурласан байх.

Зургаа. Оролцоо

6.1. Төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үнэлэх явцад Авлигатай тэмцэх газар, төрийн байгууллагууд, “Шинжээчдийн баг” нь дараахь байдлаар оролцоно:

а/ Авлигатай тэмцэх газар:

- Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжүүлж буй байгууллагын жагсаалтыг гаргах;
- Төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн тайланг хүлээн авах, хуулбарыг “Шинжээчдийн баг”-т хүргүүлэх;
- Нотлох баримтыг цуглуулах, төрийн байгууллагын холбогдох албан тушаалтныг “Шинжээчдийн баг”-тай холбож өгөх;
- Шаардлагатай мэдээллийг шинжээчид гаргаж өгөх бөгөөд тус багийн үйл ажиллагаанд дэмжлэг, тусалцаа үзүүлэх;
- Сайн туршлагыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;
- Үнэлгээнд хамрагдсан байгууллагуудад үнэлгээний дүнг хүргүүлэх;
- Үнэлгээний дүн, тайлан мэдээг холбогдох байгууллага /ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газар, яам, Төрийн өмчийн хороо, аймаг, нийслэлийн Засаг дарга г.м/, албан тушаалтанд хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх.

б/ Төрийн байгууллагууд:

- Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг тогтсон хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;
- Шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгөх;
- Мэдээллээ цахим хуудас, мэдээллийн самбартаа тогтмол байршуулах;
- Төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газраас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах.

в/ Шинжээчдийн баг:

- Үнэлгээний тайланг тогтсон хугацаанд гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;
- Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллах. Шинжээчдийн багийн гүйцэтгэх ажлыг “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд тодорхой тусгана.

Долоо. Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явц

	Үе шат	Агуулга	Хугацаа
I	Боловсруулах	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан бат-	1-2 дугаар сар

		лах, Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх <i>/Төрийн байгууллагууд/</i>	
II	Хэрэгжүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх <i>/Төрийн байгууллагууд/</i>	2-11 дүгээр сар
III	Тайлагнах	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг нотлох баримтын хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх <i>/Төрийн байгууллагууд/</i>	11 дүгээр сарын 15
IV	Үнэлэх	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайлан, нотлох баримт, газар дээр нь ажиллах замаар үнэлгээ хийх <i>/Шинжээчдийн баг/</i>	11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 5-ны дотор
V	Мэдээлэх	Үр дүнг мэдээлэх <i>/Шинжээчдийн баг, Авлигатай тэмцэх газар/</i>	Жил бүрийн 12 сарын 9

Найм. Үнэлгээний агуулга, арга зүй

Үнэлгээний агуулга нь хуулиар хүлээсэн үүргийн биелэлт, Авлигатай тэмцэх санал, санаачилга гэсэн 2 үндсэн хэсэг, 20 дэд хэсгээс бүрдэнэ. Дэд хэсгийн хүрээнд хийх ажлын агуулгыг “Шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал” хэсгээс харна уу.

Авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэхдээ төрийн байгууллагын тухайн жилд хийхээр төлөвлөсөн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланд үндэслэхийн зэрэгцээ нотлох баримт */цахим хуудас, хавсарган ирүүлсэн материал/-*д шинжилгээ хийнэ. Тухайлбал, аргачлалын “Шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал”-ын гүйцэтгэлийн үзүүлэлтийн 9.1.4.1, 9.1.4.2, 9.1.4.3-ыг үнэлэхдээ тухайн байгууллагын цахим хуудсанд хандалт хийж байршуулсан эсэх, мөн 9.1.4.9, 9.1.4.10-ыг үнэлэхдээ тухайн мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан эсэхийг Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалттай тулгалт хийх, 9.1.15.1, 9.1.2.4-ийг үнэлэхдээ тухайн байгууллагаас ирүүлсэн тайланд энэ талаар хэрхэн тусгасан, түүнийг илтгэх нотлох баримт ирүүлсэн зэргийг шинжлэх замаар үнэлж, зохих оноог өгнө. Түүнчлэн зарим тохиолдолд газар дээр нь биечлэн ажиллах, Авлигатай тэмцэх газар тухайн төрийн байгууллага хооронд бүтэн жилийн турш шалгуур үзүүлэлтэд дурдсан асуудлаар харилцсан албан бичиг, холбогдох баримт бичиг зэргийг үнэлгээнд ашиглана.

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх ажлыг Авлигатай тэмцэх газраас нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулсан иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий “Шинжээчдийн баг” гүйцэтгэх бөгөөд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга, шинжээчдийн багийн ахлагчтай ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, төсвийн шууд захирагчаар баталгаажуулан ажиллана.

Үнэлгээнд Улсын Их Хурлын байгууллагууд, яамд, Засгийн газрын агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн дүүргүүд, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагууд хамрагдах бөгөөд төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхдээ тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг харгалзан “Шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал”-ын зарим дэд хэсгийг үнэлэхгүй байж болно. Энэ

тохиолдолд шинжээчдийн баг, Авлигатай тэмцэх газрын зөвшөөрлийг авсан байх ба шалгарсан “Шинжээчдийг баг” нь тус газартай хамтран аргачлалын үндсэн агуулгыг алдагдуулахгүйгээр тохирсон шалгуур үзүүлэлтийг боловсруулан мөрдөж болно.

Шүүх эрх мэдлийн байгууллагууд болох бүх шатны прокурор, шүүх, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг үнэлэхгүй. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг үнэлэхгүй ба нууцын тухай хууль тогтоомжоор нууцад хамаарч буй асуудлын талаарх мэдээллийг ирүүлэхгүй байх талаар тухайн байгууллага холбогдох арга хэмжээг авбал зохино.

Ес. Шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлал

9.1. Хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, Авлигатай тэмцэх санал, санаачилгыг 0-30 оноогоор тус тус үнэлнэ.

Хуулиар хүлээсэн үүргийн биелэлт				
Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур		Тайлбар
		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Оноо	
9.1.1	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хууль 5 дугаар зүйлийн 5.1.2; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5; Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2. 	<p>9.1.1.1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/</p> <p>9.1.1.2. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх</p>	0-2	<p>АТГ-аас төрийн байгууллагуудад хүргүүлсэн материалын бүртгэлийг хөтлөх бөгөөд төрийн байгууллагуудын түгээлтийн бүртгэлд үндэслэн үнэлэх</p>
9.1.2	<p>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p>	<p>9.1.2.1. Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх</p>	0-3	<p>Тухайн жилд боловсруулж батлуулахаар төлөвлөсөн баримт бичиг, шийдвэрийн тоотой харьцуулалт хийж үнэлэх</p>

	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 	<p>9.1.2.2.Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>9.1.2.3.Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх</p>		<p>Хэм хэмжээ тогтоосон актын тухайд тухайн онд ХЗЯ-нд бүртгүүлсэн бүртгэлд үндэслэх</p> <p>Зөвхөн нотлох баримтад үндэслэж үнэлэх</p>
9.1.3	<p>Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 	<p>9.1.3.1.Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө /төлөвлөгөөт/-г цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>9.1.3.2. Хийсэн хяналт шалгалтынхаа дүнг олон нийтэд мэдээлсэн байх /цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн байх/</p> <p>9.1.3.3.Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх</p>	0-3	<p>Гадагш чиглэсэн хяналт шалгалт хамаарах ба төлөвлөгөөнд туссан хяналт шалгалтын төрөл, тоотой харьцуулалт хийж үнэлэх</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн тохиолдолд тайланд энэ тухай дурдаж нотлох баримтыг хавсаргасан байх</p>
9.1.4	<p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл 	<p>9.1.4.1. Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.4.2.Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/-г цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.4.3.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /4 дүгээр сарын 1-ний дотор/-ийг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.4.4.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх /өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт/</p> <p>9.1.4.5.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох /татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл/</p> <p>9.1.4.6. Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бат-</p>	0-10	<p>Төсвийн тухай, Аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудад заасан хугацааг харгалзан үзэх</p> <p>ЭЗХЯ /СЯ/,</p>

		лагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх		Аймаг, нийслэлийн ЗД
		9.1.4.7.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх		Тухайн байгууллагын мэдээлэл, эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад харицуулалт хийж үнэлэх
		9.1.4.8.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах		--
		9.1.4.9.Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах		Нийгмийн даатгалын ерөнхий газраас авсан баримтад тулгуурлах
		9.1.4.10.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах		Улсын хэмжээнд гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн жагсаалт /СЯ/-д тулгуурлах
9.1.5	<p>Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, олон нийтэд танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8 	9.1.5.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	0-4	Аливаа зөвшөөрөл олгодоггүй бол энэ талаар тайланд тусгасан байх
		9.1.5.2.Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах		
		9.1.5.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрх-		

		лэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах		
		9.1.5.4.Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа ил тод болгох		Хуульд зааснаар бүртгэл хийхээр тусгасан бүртгэлүүд хамаарах ба бүртгэл хийдэггүй үндэслэлээ тайланд тусгах
9.1.6	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8 дугаар зүйл 	<p>9.1.6.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/</p> <p>9.1.6.2.Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх</p>	0-2	Тухайн жилд томилогдсон албан хаагчийн тоонд харицуулалт хийж үнэлэх ба төрийн байгууллагаас ТАЗ-д хүргүүлсэн сул орон тооны мэдээлэлд тулгуурлах
9.1.7	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10 дугаар зүйл • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйл, 47 дугаар зүйлийн 47.4, 48 дугаар зүйлийн 48.5 	<p>9.1.7.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.7.2.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>9.1.7.3.Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх</p> <p>9.1.7.4.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах</p> <p>9.1.7.5.Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх</p> <p>9.1.7.6.Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх</p> <p>9.1.7.7.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хя-</p>	0-8	<p>Тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш 1 сарын дотор</p> <p>Төлөвлөгөө, гүйцэтгэлд тулгуурлах</p> <p>Аудитын байгууллагаас хийсэн тайлан, дүгнэлттэй</p>

		налт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах		тулгалт хийн үнэлэх
		9.1.7.8.Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх		Үнэлгээний хороо байгуулсан шийдвэрт үндэслэн үнэлэх
9.1.8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6	9.1.8.1.Төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлсэн байх 9.1.8.2.Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох	0-2	Тайланд үндэслэх
9.1.9	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7, 6.1.13; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.3	9.1.9.1.Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх /1 ба түүнээс дээш/ 9.1.9.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг тайландаа тусгасан байх 9.1.9.3.Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	0-3	Сонгон шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ХМХ-ээр мэдээлсэн тохиолдолд ямар эх сурвалжаас үзэхийг тайланд тусгасан байх
9.1.10	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх Эрх зүйн үндэслэл: • Авлигын эсрэг хууль 6 дугаар зүйлийн 6.1.8; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2	9.1.10.1.Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх 9.1.10.2.ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх 9.1.10.3.Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх 9.1.10.4.ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх	0-4	Томилсон шийдвэрт үндэслэх Ажлын байрны тодорхойлолтыг харж үнэлэх АТГ дахь бүртгэлийг үндэслэх АТГ /ХШДШХ/-ын үнэлгээ байна.
9.1.11	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	9.1.11.1.Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх		

	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл, 29 дүгээр зүйл; Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.8, 6.1.6 	<p>9.1.11.2.Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх /албан хаагчдад танилцуулсан байдал/</p> <p>9.1.11.3.Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуулах г.м/-ийг бүрдүүлсэн байх</p> <p>9.1.11.3.Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах</p> <p>9.1.11.4.Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх</p> <p>9.1.11.5.Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх</p>	0-6	
9.1.12	<p>Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6, 19 дүгээр зүйл 	<p>9.1.12.1.Хууль болон Засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх</p> <p>9.1.12.2.Давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх</p>	0-2	
9.1.13	<p>Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 9.1.5 	<p>9.1.13.1.Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх /цахим хуудсаар/</p> <p>9.1.13.2.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.13.3.Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж /хуульчилсан акт/, дүрэм, журам, зааврыг цахим хуудсандаа байршуулах</p> <p>9.1.13.4.Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах</p>	0-4	<p>Тухайн жилд гаргасан бүх шийдвэрт харьцуулалт хийж үнэлэх</p> <p>Тухайн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан үнэлэх</p> <p>Төлбөр, хураамж авдаггүй бол энэ тухай тайланд тусгах</p>
9.1.14	<p>Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах</p>	<p>9.1.14.1.Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх</p>		

	<p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3; • Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 8, 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг 	<p>9.1.14.2.Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p> <p>9.1.14.3.Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах</p> <p>9.1.14.4.Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх</p>	0-4	
9.1.15	<p>Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 	<p>9.1.15.1.Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх</p> <p>9.1.15.2.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/</p>	0-2	
9.1.16	<p>Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4; • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 		0-1	ТӨХ болон аймаг, нийслэлийн ИТХ-аас төрийн болон орон нутгийн өмчийн байранд түрээсийн гэрээгээр байрлаж буй байгууллагуудын жагсаалтад үндэслэх

9.1.17	<p>Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.7, 18 дугаар зүйлийн 18.4.2, 29 дүгээр зүйлийн 29.4; • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 	<p>9.1.17.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн Зөвлөмжийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p> <p>9.1.17.2.АТГ-ын мөрдөн байцаагчаас гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдлийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p> <p>9.1.17.3.АТГ-аас зөрчил арилгуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт, зохион байгуулсан арга хэмжээ</p> <p>9.1.17.4.АТГ-аас хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар хүргүүлсэн албан бичгийн биелэлт</p> <p>9.1.17.5.Авлига гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн дүрэм, журам, заавар, шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгосон эсэх</p> <p>9.1.17.6.АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ</p>	0-10	<p>Авлигатай тэмцэх газраас аливаа шийдвэр хүргүүлээгүй тохиолдолд бүтэн оноо өгч үнэлэх</p> <p>/АТГ-аас мэдээллийг өгөх/</p>
Авлигатай тэмцэх санал, санаачилга				
Дэд хэсэг	Хийх ажлын агуулга	Шалгуур		Тайлбар
		Гүйцэтгэлийн үзүүлэлт	Оноо	
9.1.2	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх</p> <p>Эрх зүйн үндэслэл:</p> <ul style="list-style-type: none"> • Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2; 	<p>9.1.2.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх</p> <p>9.1.2.2.Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх</p> <p>9.1.2.3.Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/нд АТГ-т хүргүүлсэн байх</p> <p>9.1.2.4.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх</p>	0-5	
9.1.2	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	9.1.2.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга /уриа, уриалга, мэ-		

		дэгдэл, амлалт г.м/-д нэгдсэн байдал	0-15	
		9.1.2.2.Удирдах алба тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, санаачилга, тэдний үлгэр жишээ байдал		
		9.1.2.3.Авлигын эсрэг арга хэмжээнд зориулан тусгайлан хөрөнгө гаргасан эсэх /зарцуулалт/		
		9.1.2.4.Удирдлагын хүсэл, эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлын талаар ажилтнуудаас өгсөн үнэлгээ		“Шинжээчдийн баг”-аас тусгайлан боловсруулсан санал асуулгаар үнэлэх
9.1.3	Албан хаагчдын шударга байдал ба түүнийг нэмэгдүүлэх	9.1.3.1.Албан тушаалтан, албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ /шударга ёс, ёс зүй, сонирхлын зөрчлийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, өдөрлөг, зөвлөмж өгөх г.м/-г авах	0-10	
		9.1.3.2.Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авсан арга хэмжээ		
		9.1.3.3.Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ	+10	Нэмэх оноо
		9.1.3.4.Бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ	-5	Хасах оноо
		9.1.3.5.Шүүхээр шийдэгдсэн Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчил	-5	Хасах оноо

9.2. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилт нь нийт 100 оноогоор үнэлэгдэнэ.

9.3. Авлигатай тэмцэх санал, санаачилга хэсгийн байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн авлигын зөрчил, авсан арга хэмжээ, түүний үр дүн, санаачилгыг харгалзан 10 хүртэл нэмэх оноо өгөх бөгөөд бусад байгууллага, иргэдийн гомдлоор илэрсэн зөрчил, авсан арга хэмжээ, Авлигатай тэмцэх газрын шалгалтаар илэрсэн авлигын гэмт хэрэг ба бусад зөрчлийг харгалзан тус тус 5 хүртэл хасах оноо өгч үнэлнэ.

9.4. Үнэлгээнд хамрагдсан байгууллага нь 3 жил дараалан 90-ээс дээш оноо авсан тохиолдолд тодорхой хугацаанд үнэлгээнд хамрагдахаас чөлөөлж болно.

9.5. Авлигатай тэмцэх газар нь аргачлалын “Ес”-ийн 9.3 болон бусад Авлигатай тэмцэх газраас шалтгаалан үнэлэх ажлын үнэлгээг Шинжээчдийн багт хүргүүлсэн байна.

Арав. Тайлагналт, үр дүнг мэдээлэх

10.1. Төрийн байгууллагууд нь авлигын эсрэг үйл ажиллагаа /төлөвлөгөө/-ны гүйцэтгэлийн тайланг, нотлох баримтын хамт тухайн жилийн 11 дүгээр сарын 15-ны дотор Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

10.2. Шинжээчдийн баг нь Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, нотлох баримтад үндэслэн тухайн жилийн 11 дүгээр сарын 15-наас 12 дугаар сарын 5-ны дотор үнэлгээ хийх бөгөөд тайлан, дүнг Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

10.3. Төрийн байгууллагууд авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээл, хүрсэн үр дүн, ололт амжилтыг тайланд тусгахын зэрэгцээ үнэлгээтэй холбоотой саналаа Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх нь нээлттэй. Төрийн байгууллагуудын болон Шинжээчдийн багийн саналыг үндэслэн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлэх аргачлал, шалгуурт өөрчлөлт оруулж болно. Өөрчлөлт орсон даруй төрийн байгууллагуудад мэдэгдэнэ.

10.4. Шинжээчдийн баг болон Авлигатай тэмцэх газар нь үнэлгээ, түүний үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 9 буюу “Авлигын эсрэг” олон улсын өдөр олон нийтэд мэдээлнэ.

10.5. Авлигатай тэмцэх газар нь шинжээчдийн багаас ирүүлсэн тайлан, түүний үр дүнг Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар болон төрийн захиргааны төв байгууллага /эрхлэх асуудлын хүрээний агентлагын үнэлгээг/-д хүргүүлэх бөгөөд төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ нь яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг байна.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР